

**МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН СУДАЛГАА**

**Улаанбаатар хот 2020 он
МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ
ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДСАН ТУХАЙ ТАЙЛАНГИЙН АГУУЛГА**

НЭГ. Ерөнхий мэдээлэл

ХОЁР. Асуудлын дүн шинжилгээ

ГУРАВ. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал

ДӨРӨВ. Асуудлыг зохицуулах хувилбарууд, эерэг болон сөрөг тал дээр хийсэн харьцуулалт

ТАВ. Сонгосон хувилбарын үр нөлөөг тандан судалсан байдал

ЗУРГАА. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт

ДОЛОО. Олон улсын болон бусад улсын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал

НАЙМ. Зөвлөмж

НЭГ. Ерөнхий мэдээлэл

Дэлхий дахинд мэдээлэл, түүнд хийгдэж буй олборлолт, шинжилгээний ажлын үнэлэмж, үнэ цэнэ өдөр ирэх тусам үлэмж ихээр нэмэгдэж байна. Хэдхэн жилийн өмнө хатуу дэд бүтцийг эзэмшигч компани, бизнес, төр хамгийн хүчтэй гэгдэж байсан бол өнөө цагт мэдээллийг олж чаддаг, олсон мэдээлэлдээ зөв үнэлэлт, дүгнэлт хийж чаддаг төр, бизнесийг хамгийн хүчтэй гэж томъёолох болжээ. Иймээс ч дараагийн “газрын тос” бол мэдээлэл юм гэж дуу нэгтэйгээр хүлээн зөвшөөрч байна.

Энэ чиг хандлагаас Монголын төр, Улсын Их Хурал, Засгийн Газар аль болох хоцрохгүйг хичээн ажилласаар байна. 2020-2024 оны Улсын Их Хурал анх удаа өөрийн бүтэцдээ Инноваци, цахим бодлогын байнгын хороог байгуулж, төр дээрээс доош хүртэлх бүхий л шатандаа дижиталчлал, цахим шилжилтийг урамшуулан өөрийн тэргүүлэх чиглэлийн нэг гэж үзэж байгаа нь тун сайшаалтай. Түүнчлэн сүүлийн жилүүдэд залуучуудын дунд дата, өгөгдөл дээр тулгуурласан бизнес эрхлэх сонирхол ихээхэн нэмэгдэж, төрд хуримтлагдаж буй харилцагчийн хувийн мэдээлэл ХУР, ДАН системийн өгөгдөлд үндэслэн зээл олгох мэт үйлчилгээ, бизнесүүд ихээхэн нэмэгдэж байна. Энэ төрлийн бизнес эрхлэгч компаниуд эхнээсээ дотоодын зах зээлд хөрөнгө босгоод зогсохгүй, гадагшаа гарч олон улсаас хөрөнгө мөнгө босгож, дэлхийд өрсөлдөхөөр тэмүүлцгээж байна.

Гэвч ХУР, ДАН мэт шиг хувийн өндөр түвшний мэдээлэл үл шаардах бөгөөд статистик мэдээллээс илүү боловсруулагдсан зарим төрлийн мэдээллийг төрд үүсэн буй өгөгдлийг ашиглан борлуулж улсын төсөвт шинэ орлогын эх үүсвэр бий болгох, мэдээллийг ашиглагч бизнесүүд, старатуудад өгөгдөл олборлолт, шинжилгээ хийх түүхий эдийг бий болгох хэн хэн нь цугтаа хожих шийдлийг бүрдүүлэх боломжийг бүрдүүлэх боломжийг тандан судлахаар уг тайланг гүйцэтгэв.

ХОЁР. АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Мөн чанар, цар хүрээг тогтоох

Хүн төрөлхтний нийт өгөгдлийн 90 хувь нь сүүлийн хоёр жилд үүссэн гэдэг сонирхолтой судалгааг 2016 онд IBM компани гаргаж байв. Нийгмийн сүлжээ, юмсын интернет (internet of things) зэрэг технологиудын үсрэнгүй өсөлтүүдийн нөлөөгөөр өгөгдлийн хэмжээ, үүсэх давтамж нэмэгдэхийн хирээр түүнийг ашиглаж чадсанд үлэмж их өгөөж, үнэ цэнийг авчирч өрсөлдөх чадварыг нь нэмж байгааг эргэн тойрны олон жишээнээс бид харж чадах байна. Иймдээ ч өгөгдлийг шинэ газрын тос гэж онцолж байна. Үнэхээр өгөгдөл бол түүхий эд бөгөөд түүнд боловсруулалт хийснээр мэдээлэлд үндэслэсэн оновчтой шийдэл, шийдвэр гаргалт гарах бөгөөд энэ нь таамаглал, сэтгэл хөдлөлд суурилсан шийдлүүдээс хэд дахин өндөр үр дүнтэй байгаа тул ашигласан нь хожиж, хоцорсон нь ялагдсаар байна.

МЭӨ 3000 оны үед хүн төрөлхтөн шавар хавтан, гулдмайд анхны өгөгдлүүдийг хадгалж эхэлснээс хойш түүнийг хадгалах хэлбэр, зориулалт нь цаг

тутам өөрчлөгдөхийн хирээр түүний үнэ цэнэ улам бүр өссөөр өнөө цагт оргилдоо хүрснийг дээрх тоо баримт харуулна. Өгөгдөл буюу дата гэх үгээр илэрхийлэгдэж байсан уг ойлголт өдгөө хүрээ, хязгаараа тэлж биг дата буюу их өгөгдлийн түвшинд яригдаж байна.

Иймдээ ч статистик мэдээлэл, тооллого, судалгаагаар өгөгдлийн хэлбэр хязгаарлагдахаа больж, технологийн дэвшлийн тусламжтай өдөр тутмын энгийн үйлдлүүд ч өгөгдөл болон хадгалагдах болсон. Үүний нэг нь иргэдийн төрөөс авч буй үйлчилгээний өгөгдөл юм. 2020 оны 10 сарын 28-ны өдөр өөртөө 181 үйлчилгээг нэгтгээд байгаа төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-ийн талаарх ээлжит мэдээллийг өгөхдөө хэлсэн үгэндээ Татварын Ерөнхий газрын дарга З.Заяабал “E-Mongolia”-ийн хүрээнд төрийн байгууллагууд хоорондоо уялдаатай болж, мэдээллийг цаасаар бус цахимаар авах боломж бүрдэж байна. Татвартай холбоотой үндсэн 48 үйлчилгээ цахим боллоо. Татварын системүүдээр нэг минутад 340 орчим иргэн, нэг цагт 21,000 орчим иргэд үйлчилгээ авдаг. Эхний есөн сарын дотор зөвхөн цахимаар хүсэлт гаргаж, тодорхойлолт авсан иргэдийн тоо давхардсан байдлаар 1,589,643-т хүрлээ. Өнгөрсөн жил 422 мянган татвар төлөгчдөд цахимаар үйлчилгээ үзүүлсэн бол энэ оны эхний есөн сарын байдлаар 616 мянган иргэнд цахим үйлчилгээ үзүүлсэн байна” гэж хэлсэн. Мөн Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ “E-Mongolia 10 дугаар сарын 1-нд нээлтээ хийснээс хойш сар гаруй хугацаанд 179,253 иргэн хандсан байна” гэж хэлж байв. Зөвхөн дээрх 2 мэдээллээс харахад төрийн үйлчилгээг даган ямархуу хэмжээний их өгөгдөл үүсч байгааг барагцаалж болно. Гэвч энэхүү их өгөгдлийг төрийн байгууллагын серверт хадгалах биш эргэлтэнд оруулж, иргэд, хувийн хэвшилдээ хуваалцах цаг нэгэнт иржээ.

Нэмэгдсэн өртгийн албан татварыг цахимаар бүртгэх ebarimt.mn систем нь хэрэглээнд нэвтрүүлж эхэлснээс иргэдийн өдөр тутамд ашигладаг хэрэглүүрүүдийн нэг болж, сар бүр 40 сая орчим баримт систем рүү илгээгдэж байна. Эдгээр баримт бүр нь өөр дээрээ барааны бүлэг, нэр төрлийн мэдээллийг агуулсан их өгөгдлийг агуулж буй. Энэхүү өгөгдлөөс хаана, ямар төрлийн барааны борлуулалт сайн байгаа, ямар бүтээгдэхүүн илүү эрэлттэй байгаа, хэрэглээний чиг хандлага хаашаа явж байгаа гэх мэт бизнесүүд, тэр тусмаа анхлан бизнес эрхэлж буй иргэд, залуу бизнесменүүдэд зүг чиг болох мэдээллүүдийг гаргах бүрэн боломжтой юм. Нэг талд энэхүү төрлийн мэдээлэл үүсэн хуримтлагдаж, эргэлтэнд оролгүй хадгалагдаж байхад нөгөө талд ямар чиглэлээр бизнес эрхлэх, ямар бүтээгдэхүүнийг хөгжүүлэхээ эрэн хайж буй залуучууд өөрсдийн боломжоороо судалгаа хийж, нотолгоотой эх үүсвэргүй судалгаанаас үүдэн өөрийн хөрөнгө санхүү, цаг заваа алдах явдлууд байсаар байна. Иймд дээрх өгөгдлийг боловсруулан хувь хүний болон байгууллагын нууцад хамаарах мэдээллийг нуун, барааны бүлэг, байршил, нэр төрөл, тоо хэмжээ, үнийн дүнгийн түвшинд тойм мэдээлэл бүхий тайлан, судалгаа, өгөгдлийг үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс үнэлэн бизнесүүдэд борлуулах боломжтой гэж үзэж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий бүртгэлийн газрын мэдээллээр 2019 оны 1 сараас 11 сард 414,587 ширхэг, 2020 оны мөн хугацаанд 409,914 ширхэг эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байдаг. Үүний 1/4 нь анхлан эд хөрөнгөө бүртгүүлж буй бол үлдэх хэсэг нь өөрийн үл хөдлөх хөрөнгөө эргэлтэнд

оруулж буй бүртгэл байна. Энэхүү бүртгэлүүд нь мөн л бодит зах зээлийн мэдээллийг агуулсан эрэлт хэрэгцээтэй үл хөдлөх, орон сууц, хашаа байшинг эргэлтэнд оруулсан солилцооны мэдээллийг агуулсан асар их ач холбогдолтой өгөгдөл юм. Зөвхөн 2020 оны 11-р сарын дүнгээр үзэхэд 28,899 ширхэг гэрээ, солилцоог бүртгэсэн үйлчилгээний өгөгдөл үүсэн, өмнөх дүнгүүдээр хуримтлагдсан өөрийн үнэ цэнэ бүхий, зах зээлд эрэлт хэрэгцээ бүхий уг мэдээлэл “агуулахт” сул хэвтэж байхад өнгөрсөн хугацаанд хаана, ямар төрлийн үл хөдлөх, орон сууц, хашаа байшин эрэлттэй байв, цаашид чиг хандлага хааш чиглэх вэ? гэдэгт хариулт олохоор үл хөдлөх хөгжүүлэгчид, барилгын компаниуд, банк санхүүгийн байгууллагууд тус тусдаа судалгаа хийн алдаж, онон явсаар байна. Иймд энэхүү мэдээллийг эргэлтэнд оруулж, төсөвт орлогын шинэ боломжийг бий болгох, зах зээлийн тоглогч нарт үнэ цэнэ бүхий өгөгдлийг хүргэх боломж байсаар байна.

Иргэдийн зээлжих зэрэглэл, зээлийн түүхийг агуулсан Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа, харилцаа нь тусдаа хуулиар зохицуулагддаг. Мөн Төв банкны тухай, Гаалийн тухай хуулиудад эдгээр байгууллагууд өөрсдийн мэдээллийг нэгтгэн статистик мэдээлэл гаргах, бүр түүнийгээ тусгай журмаар үнэлэх зохицуулалт ч тусгасан байдаг. Харин дээрх 2 мэдээллийн хувьд авч ашиглах боломжтой, сан өгөгдөл нь хангалттай сайн үүссэн ч зохицуулах шийдэл өнөөг хүртэл хууль, тогтоомжид тусаагүй байна.

Төрөөс иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хүргэж буй 800 орчим үйлчилгээ байдаг тухай судалгаа бий. Үүнээс иргэд, бизнесүүдэд ихээхэн үнэ цэнэ өгөх, Монголын бизнесийн бүтээмж, өгөөжийг нэмэгдүүлэх, эдийн засгийг солонгоруулахад дэм болох гадаадын хөрөнгө оруулагчдыг дэмжих энэ мэт өгөгдлүүдийг ялган ашиглах боломжийг бүрдүүлэх шаардлага байна гэж үзэж байна.

Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох

Уг зохицуулалттай холбоотойгоор дараах бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын эрх ашиг хөндөгдөж байна гэж үзэж байна.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1 Бизнес эрхлэгчид, шинээр бизнес эрхлэх хүсэлтэй иргэд, залуучууд	Бизнес эрхлэгчид, тэр тусмаа шинээр бизнес эхлүүлж буй стартапуудад ямар чиглэлээр бизнесээ эхлүүлэх вэ?, ямар төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ эрэлттэй байна вэ?, миний олсон санаа шийдэлд өөр хэн нэгэн хөрөнгө оруулалт хийж байна уу? гэдэг асуудал үргэлж ач холбогдолтой байдаг. Иймд энэхүү асуултанд хариулт олж, өөрсдийн хийж буй хөрөнгө оруулалтаа үр ашигтай, өгөөжтэй байлгахын тулд судалгаа, мэдээлэлд анхаарал хандуулдаг. Өнөөгийн нөхцөлд судалгааг өөрсдийн таамаглал ,төсөөлөлд үндэслэн тодорхойлсон хүрээгээр хийдэг боловч мэдээлэл дутуу, хүрээ, олонлогийг буруу

		тооцоолсон зэргээс хамааран хангалттай үр дүн гарахгүй байх тохиолдлууд их байдаг. Гэтэл эдгээр тал талд бизнесүүдийн хүч гарган судалж, алдаж онож буй энэ бүх асуудлуудын шийдэл, үр дүнг өөрийн үзүүлсэн үйлчилгээнийхээ үр дүнгээр нэгтгэсэн төрийн зарим мэдээлэл өнөө хүртэл хаалттай байгаа явдлууд байна. Ийм мэдээллүүдийг бизнесийн хүсэл шаардлагыг хангуулах нээлттэй болгох шаардлага байна.
2	Иргэд	Нэг бизнесийн амжилттай, алдагдалтай байх нь зөвхөн тухайн бизнесмений асуудал биш иргэд, төрийн байгууллагад ч нөлөөтэй. Ашиглаж болох өгөгдөл мэдээллийг ашиглаж чадаагүйгээс үүдэн амжилтгүй хөрөнгө оруулалт хийж, иргэдийн ажлын байр, цалин хөлсөнд асуудал гардаг.
3	Төр байгууллага	Төр, түүний бүтцийн байгууллагуудын үндсэн үүрэг, зорилго нь иргэд, хувийн хэвшилд ээлтэй орчин, дэд бүтцийг бий болгох явдал. Үүний үр дүнд татвар, төсвийн бодлогоороо дамжуулан дахин хуваарилалтыг үр ашигтай хийх нь мөн чухал. Тэгвэл хуулийн нэмэлтийг хийснээр дээрх 2 шаардлагыг бүрэн хангах боломжтой.

Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөл

Өгөгдөл, тоон мэдээлэлд Монголын төрийн зүгээс ач холбогдол өгөн холбогдох хуулиудад тодорхой тусгасан байдаг. 1997 онд Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хийж, Статистикийн төв байгууллага Улсын Их Хурлын харьяанд бие даасан байдлаар үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн Гаалийн тухай хууль, Төв банкны тухай хуулиудад эдгээр байгууллагууд нь өөрсдийн статистикийг гаргахыг хуульчлан заасан байдаг.

Статистикийн тухай хуулийн 6-р зүйлд “Албан ёсны статистикийн мэдээлэлд дараахь үндсэн үзүүлэлт хамаарна” гээд

1/макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт:

- а/ дотоодын нийт бүтээгдэхүүн;
- б/ инфляцийн түвшин, хэрэглээний үнэ;
- в/ хөрөнгө оруулалт;
- г/ хуримтлал;
- д/ төлбөрийн тэнцэл;
- е/ ажилгүйчүүдийн тоо;
- ё/ мөнгө, банкны зээл , үнэт цаасны зах зээл;
- ж/ улс, орон нутгийн төсвийн орлого, зарлага;
- з/ бүтээмжийн үзүүлэлтүүд.

2/хүн ам, нийгмийн статистикийн үзүүлэлт;

а/ хүн амын тоо, нас, хүйс,

б/ хүн амын төрөлт, нас баралт, цэвэр өсөлт, гэрлэлт, гэр бүл цуцлалт;

в/ эдийн засгийн идэвхтэй хүн ам, ажиллагсад;

г/ өрх, хүн амын орлого, зарлага, хэрэглээ;

д/ хүн амын хүнсний хангамж, хүртээмж, илчлэг, шим тэжээлийн болон чанар, эрүүл ахуйн үзүүлэлт;

е/ хүн амын амьжиргааны түвшин, ядуурал;

ё/ дундаж цалин, орлого

ж/ хүн амын боловсролын түвшин, сургууль, багш, суралцагсдын тоо;

з/ хүн амын эрүүл мэнд, эмнэлэг, эмч, өвчлөгчдийн тоо;

и/ орон сууцны сан, шинээр барьсан сууц;

к/ тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ;

л/ музей, номын сангийн тоо, тэдгээрийн сан хөмрөг;

м/ сонин, сэтгүүл, үйлдвэрлэсэн киноны тоо;

н/ ажлын цагийн үргэлжлэл.

о/ үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого;

п/ хөдөлмөрийн маргаан.

3/үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологийн статистикийн үзүүлэлт:

а/ мал, тэжээвэр амьтдын тоо;

б/ малын хашаа худаг, уст цэгийн тоо;

в/ хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл;

г/ тариалсан талбай, хураасан ургац, өвс, тэжээл;

д/ аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт;

е/ аж үйлдвэрийн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл;

ё/ барилга угсралт, их засварын ажлын хэмжээ;

ж/ тээврийн салбарын тээсэн ачаа, зорчигч, ачаа эргэлт, зорчигч эргэлт;

з / холбооны үйлчилгээний орлого, радио, телефон цэгийн тоо;

и/ экспорт, импортын гол нэр төрөл, хэмжээ;

к/ аялал жуулчлалын орлого, жуулчдын тоо;

л/ мөрдөж байгаа патент, шинэ бүтээлийн тоо;

м/ эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын зардал;

4/шүүхийн статистикийн үзүүлэлт:

а/ эрүүгийн хэргийн тоо, төрөл;

б/ шүүхээр шийтгүүлэгчдийн тоо, нас, хүйсний ялгаа;

в/ гэмт хэргийн улмаас учирсан хохирол;

г/ дампуурсан аж ахуйн нэгж;

д/ захиргааны болон иргэний хэргийн үзүүлэлт;

5/ хүрээлэн байгаа орчны статистикийн үзүүлэлт:

а/ газрын хөрсний хамгаалалт, эвдрэл;

б/ цэвэр усны нөөц, ус ашиглалт, бохирдолт, цэвэрлэгээ, хаягдал;

в/ агаарын бохирдол;

г/ ойн хамгаалалт, нөхөн сэргээлт;

д/ дархан цаазтай амьтны тоо, агнуур гэж нарийвчлан зааж өгсөн байдаг.

Мөн жил бүр болон тодорхой хугацаан тооллого, судалгааг хийхээр зааж, түүнд ногдох зардлыг улсын төсөвт тусгахыг хуульчилсан. Улсын Их Хурлын харьяанд үйл ажиллагаагаа явуулж буй уг байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй үйлчилгээ нь нэгэнт стандартчлагдан, тодорхой хүрээнд өөрийн үүргээ гүйцэтгэж буй гэж үзэж болно.

Уг хуулиар тусгасан зохицуулалт, үүргийн хүрээнд статистикийн төв газраас www.1212.mn сайтыг үйл ажиллагаандаа ашиглан өнөөдрийн байдлаар 2,2 сая шахам хүн хандаж, өдрийн хандалт 5,000 орчим байгаа нь чамлахаар үзүүлэлт биш. Олон улсын хэмжээний нэгдсэн стандарт, дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж Статистикийн төв байгууллагын уг сайт өнөөдрийн байдлаар:

- Хүн ам
- Үндэсний тооцоо
- Гэр бүл, хүүхэд, залуучууд
- Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн дутуу ашиглалт, дундаж цалин
- Гадаад худалдаа
- Улсын нэгдсэн төсөв
- Эрүүл мэнд
- Аж үйлдвэр
- Жендер
- Хэрэглээний үнэ
- Мал аж аухй
- Ядуурал, өрхийн орлого, зарлага, дундаж хэрэглээ, АДТ
- Тээвэр
- Мөнгө, санхүү
- Боловсрол
- Үйлдвэрлэгчийн үнэ

- Хууль эрх зүй, гэмт хэрэг
- Бизнес регистер
- Аялал жуулчлал
- Хүрээлэн байгаа орчин
- Газар ариалан
- Мянганы хөгжийн зорилтын шалгуур үзүүлэлтүүд
- Нийгмийн даатгал, халамж
- Харилцаа холбоо
- Соёл, шинжлэх ухаан
- Барилга
- Худалдаа, зочид буудал, нийтийн хоолны салбар
- Хөрөнгө оруулалт
- Хүсний аюулгүй байдал
- Хөгжлийн бэрхшээл
- Бүтээмж
- Орон сууц, нийтийн аж ахуй
- Сүм хийд
- Засаг захиргаа, нутаг дэвсгэр
- Сонгууль
- Хүний хөгжлийн индекс
- Байгаль орчин, эдийн засгийн данс
- Төлбөрийн тэнцэл
- Тогтвортой хөгжлийн зорилт гэсэн үзүүлэлтүүдээр мэдээллийг гаргаж байна.

Статистикийн мэдээллээр төрийн байгууллагыг үнэгүй хангахаар зохицуулагдсан уг байгууллагын мэдээлэл сар, улирлаар, жилээр ихэвчлэн шинэчлэгддэг. Уг хуульд өөрчлөлт оруулах замаар шийдэж болох ч тайлагналын хугацаа зөрөх, ойлгомжгүй процесс гарах, уг мэдээлэл нь олон шинж бүхий хувьсах нөхцлүүдийг хангахгүй тул боломжгүй юм.

Мөн тусдаа өөрсдөө статистик мэдээлэл гаргах эрх бүхий хэд хэдэн байгууллага бий. Үүнээс бизнесийг дэмжих мэдээллүүдэд хамаарах Гаалийн тухай хууль, Төв банкны тухай хуулиуд хамаарна. Төв банкны мэдээллүүдэд шинжилгээ хийхэд одоогийн гаргаж буй статистик мэдээллүүд нь шаардлага хангахуйц буй юм. Гаалийн тухай хуульд статистикийн мэдээлэлтэй байх тухай тусгайлан авч үзсэн бөгөөд уг хуулийн 15.2-т “Гаалийн байгууллага нь иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр гадаад худалдааны барааны статистик мэдээллийг төлбөртэй ашиглуулж болно” гэж 15.3-т “Энэ хуулийн 15.2-т заасан төлбөрийн хэмжээг тухайн мэдээллийг гаргаж өгөхөд шаардагдах зардлаас хэтрүүлэлгүйгээр гаалийн удирдах төв байгууллагын дарга тогтооно” гэж заасан байдаг боловч уг хуулийн хэрэгжилт хангалтгүй, уг мэдээллийг олж авах нарийвчилсан журмыг зааж өгөөгүй байдал нь иргэдийн уг мэдээллийг олж авах, үйл ажиллагаандаа ашиглах боломжийг хааж байна.

Иймээс иргэдийн мэдэх, ил тод байдлыг хангуулахад чиглэсэн хуулиар уг эрхийг баталгаажуулж өгөх нь чухал юм. 2011 онд “Мэдээллийн ил тод байдал ба

мэдээлэл авах эрхийн тухай” хууль батлагдсан. Түүнээс хойш уг хуулийн зарим хэсгийн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлсон “Шилэн дансны тухай” хуулийг мөн шинээр батлан мөрдүүлсэн байдаг. Эдгээр хуулиуд нь иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг сайтар тодорхойлж өгсөн боловч төрийн үйлчилгээ болон дэд бүтцийг ашиглан цаг тутамд шинээр үүсч буй өгөгдөл, мэдээллүүдийг ашиглах боломжийг хангалттай сайн нээж өгч чадаагүй.

Нөгөө талаас уг хуулийг батлан мөрдүүлснээс хойш дэлхий дахинд болон Монголд мэдээлэл, өгөгдлийн үнэ цэнэ, ач холбогдол асар ихээр нэмэгдэж, мэдээллийн бааз сайтай, тэрхүү өгөгдлөө өндөр түвшинд боловсруулан ашиглаж чаддаг улс, бизнесийн үнэлэмж, чадамж үлэмж ихээр нэмэгдсээр байна. Цаашид ч уг хандлага тасралтгүй өсөхөөр байна. Түрэн ирж буй энэхүү шинэ нөхцөл байдал, чиг хандлагаас хоцролгүй явахад Монголын төр, УИХ, ЗГ ч чадахаараа хичээж байгаа. Гэвч төрийн дэд бүтцийг ашиглан бий болж буй цахим татварын систем Ebarimt дээр үүсч буй бүтээгдэхүүн, үйлчилгээний чиглэлээрх өгөгдөл, улсын бүртгэл дээр үүсч буй эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл, гаалийн байгууллагууд дээр үүсэн хуримтлагдаж буй бүтээгдэхүүнүүдийн нарийвчилсан импорт, экспортын мэдээлэл гэх мэт бизнесүүдэд өдөр тутам шаардлагатай, боловсруулалт, үр дүнгээс нь өндөр өгөөж хүртэж болохуйц өгөгдлүүдийг өнөөг хүртэл нээлттэй болгоогүй байна. Эдгээр өгөгдлийг нээснээр бизнес эрхлэгчид, тэр тусмаа шинээр бизнес эхлүүлэхээр зорьж буй стартапуудын хөрөнгө оруулалтын өгөөж нэмэгдэх, бүтээмж сайжрах боломжууд бүрдэнэ.

Ийм үнэ цэнэтэй, өгөөжтэй мэдээллийг ил болгож, бизнес эрхлэгчид, өгөгдөл тоон мэдээлэл дээр ажиллагчид бэлэн нөөц, олборлох түүхий эдтэй болж буй тул үүнийг шууд зардлаар нь бус үнэ цэнээр нь үнэлэн борлуулах боломжтой болно. Ингэснээр төсөвт орлогын шинэ боломж бий болно гэж үзэж байна.

Глоб интернешнл ТББ-ын зүгээс Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай уг хуулийн хэрэгжилтийн талаарх үнэлгээг хэд хэдэн хийсэн байдаг. 2018 онд хийгдсэн судалгааны тайланд “Төрийн байгууллагуудын төсөв, санхүүжилт, тендер, худалдан авалтын тухай мэдээлийг цахим болон мэдээллийн самбарт бүрэн байршуулах ёстой. Гэвч энэ талаарх мэдээлэл дутмаг байж, мэдээллийг хангах боловсон хүчнүүд төрийн байгууллагуудад байдаггүй байна.” гэж дүгнэсэн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 17-д “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ....төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж, НҮБ-ын Ерөнхий Ассемлейн анхдугаар чуулга уулзалтын 59 тоот тогтоолд заасан байдаг “Мэдээллийн эрх чөлөө бол хүний язгуур эрх бөгөөд.....НҮБ-аас эрхэмлэдэг хүний бусад эрхийн үндсэн хэмжүүр мөн” гэж заасныг иш болгож, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.4- “Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ” мөн баримт бичгийн 4.4.11-т Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний шашин

шүтэх, эс шүтэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх болон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулна” гэсний дагуу иргэдийн төрд үүсэн буй мэдээллийг авч ашиглан, бизнес хийх боломжийг бүрдүүлэх эрхийг дээрх хуулиар баталгаажуулж өгөх нь зөв гэж үзэж байна.

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэхэд дараах зорилгыг тодорхойллоо:

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд нэмэлт оруулах замаар төрд үүсэн хуримтлагдаад мэдээллүүдийг эргэлтэнд орууж, бизнес эрхлэгчид, иргэд, хуулийн этгээд үр дүнтэйгээр ашиглах, мэдээлэл боловсруулагчид үнэн зөв бодитой үнэлэлт өгч болохуйц өгөгдлийн түүхий эдтэй болох боломжтой гэж үзэж байна. Уг хуулийн нэмэлтээр дараах эрхийг баталгаажуулж чадна гэж үзэж байна. Үүнд:

- Иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
 - Өгөгдлийг нээлттэй болгосноор иргэдийн оролцоог нэмэгдүүлж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагаад төртэйгээ хамтран ажиллах боломж бий болно.
- Ил тод байдал нэмэгдэнэ.
 - Иргэдийн мэдэх эрхийг Монгол Улсын үндсэн хуулиар баталгаажуулж өгсөн. Энэхүү эрхийг тунхаг биш үйл ажиллагаа болгох, уг уг нөхцлийг бүрдүүлэхийн тулд иргэд төрөөс өөрийн хүссэн өгөгдлийг авах, түүнийгээ бусадтай хуваалцах, үүндээ боловсруулалт хийж үр дүнг хүртэх боломжийг бий болгох нь зүйтэй. Ил тод байдал гэдэг бол мэдээллийг зөвхөн ил харуулах төдий биш юм. Харин мэдээллийг бусадтай хуваалцах, анализ хийх, боловсруулах, мөн дахин ашиглах боломжоор хангахыг хэлнэ.

Бизнесийн орчин сайжирна.

Бизнесийн өгөөж сайжирч, инновацийг дэмжиж, гадаадын хөрөнгө оруулалтыг татан, эдийн засгаа солонгоруулахад дэм болно. Шинээр бизнес эхлүүлэх, бизнесийн орчныг судлахад олон өгөгдөл дээо ажиллаж судалгаа хийх хэрэгтэй болдог. Төр өөрийн өгөгдлийг нийтэд нээлттэй болгосноор инноваци бий болох, шинэ бизнесүүд төрөн гарч баялаг бүтээхэд томоохон түлхэц болно.

ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАНУУД, ЭЭРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛ ДЭЭР ХИЙСЭН ХАРЬЦУУЛАЛТ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбаруудын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг нь харьцууллаа.

“Тэг” хувилбар буюу зохицуулалт хийхээс татгалзах” буюу одоогийн байгаагаар орхиж болно. Гэвч өрсөлдөөн ширүүсч, дэлхий улам бүр хавтгайрч, нэг тэнхлэг дээр уялдан, өрсөлдөж амьдарч буй шинэ дэг журамд тун тохиромжгүй

хувилбар юм. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн дагуу үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ хангалтгүй, төрөөс тодорхой зохицуулалт хийх зайлшгүй шаардлагатай байгаа учир энэ хувилбарыг сонгох боломжгүй.

“Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх” хувилбарын хувьд иргэд, олон нийт, бизнесүүдэд түрэн ирж буй чиг хандлагын талаарх мэдээллийг хангалттай сайн өгөх боловч түүнд тохирсон түүхий эд, өгөгдлийн баазыг төр нийлүүлэхгүй тул ашиглагдах боломжгүй хувилбар.

“Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх” хувилбарын хувьд татвар, хураамжийн бодлого, зөвшөөрөл, лиценз, квотыг тогтоох замаар зохицуулдаг хувилбар. Төр өөрт буй мэдээллийг хуримтлуулан хүргэх, өгөх үйлчилгээ үзүүлж буй тул өөрийн төлбөр хураамжтай байна. Үүнийг хэн, хэрхэн тогтоох зарчмыг заавал судлах ёстой болж байна.

“Төрөөс санхүүгийн интервенц хийх” -тохиромжгүй хувилбар.

“Төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх” боломжтой боловч анхдагч буюу задгай өгөгдөл нь хувь хүний болон байгууллага, төрийн албаны нууцад хамаарах мэдээлэлтэй тул тохиромжгүй хувилбар.

“Захиргааны шийдвэр гаргах”-Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлд заасан захиргааны акт хэлбэрээр шийдвэрлэхэд тохиромжгүй гэж үзсэн тул сонгох боломжгүй.

Иймээс “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” гэсэн хувилбарыг сонголоо. Иймд тохирох хуульд нэмэлт оруулах замаар дараах асуудлуудыг шийдвэрлэх боломжтой тул “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбарыг сонгов.

ТАВ. СОНГОСОН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Сонгосон хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн хууль тус бүрээр гаргалаа.

Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь	1.1 Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Үгүй	Хуулийн төслөөр холбогдох

зарчмууда д нийцэж буй эсэх				этгээдэд тавигдах шаардлага, шалгуурыг нийтлэг, тэгшээр хуульчлагдсан.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	Нийтийн ашиг сонирхлын үүднээс тодорхой шалгуур тавьж, хязгаарлалт тогтоох боловч энэ нь ялгаварлан гадуурхсан зохицуулалт биш.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм		Бизнесүүд, тэр тусмаа гарааны бизнес эрхлэгчдийн эрхийг хамгаалахад чиглэнэ.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		Бизнес эрхлэх боломжийг дээшлүүлж байна.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн	Тийм		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг

	механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх			бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Үгүй	Хууль зөрчсөн, үүргээ зохих ёсоор биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн албан хаагчдад хүлээлгэх хариуцлагыг тухайн хуулиар зохицуулна.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		Бизнесмен, гарааны бизнес эрхлэгч
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх,		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/			
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		Төр, хуулийн этгээд үүрэг хүлээнэ
5.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		Хуулийн төслийн зохицуулалтууд бүхэлдээ жендерийн тэгш байдлыг бүрдүүлсэн.

Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1 Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх үү?		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2 Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх /эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан/?		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3 Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах уу?		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.1 Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах уу?		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.2 Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох уу?		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3 Зах зээлд шинээр орж ирж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэлийг бий болгох уу?		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4 Зах зээлд шинээр монополийг бий болгох уу?		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1 Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм		Мэдээллийг тодорхой үнэлгээгээр авах боловч энэ нь мэдээлэл нээлттэй бишээс үүдэн судалгаа хийлгэх зардлаас бага.
	3.2 Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3 Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4 Бараа, бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5 Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч буй	4.1 Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардлуудыг /Жишээ нь,		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

захиргааны зардлын ачаалал	мэдээлэх, тайлан гаргах гэх мэт/ бий болгох эсэх			
эрх 5.Өмчлөх	5.1 Өмчлөх эрхийг /үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг/ хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2 Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3 Оюуны өмчийн /патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг/ эрхийг зөрчсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
ба 6.Инноваци судалгаа шинжилгээ	6.1 Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм		
	6.2 Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч ба гэр бүлийн төсөв	7.1 Хэрэглээний үнийн төвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2 Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3 Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	7.4 Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд, мөн урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1 Тодорхой бүс нутгуудад тодорхой нэг чиглэлд, ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2 Тодорхой бүс нутгуудад тодорхой чиглэлд, ажлын байрыг багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3 Жижиг, дунд үйлдвэрүүд, эсхүл аж ахуйн нэгжийн тодорхой салбаруудад онцгой нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
9.Төрийн захиргааны байгууллага	9.1 Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Улсын төсвийг нэмэгдүүлнэ.
	9.2 Шинээр төрийн байгууллага байгуулах, эсвэл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэх шаардлага тавигдах эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3 Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм		Мэдээллийг загварын дагуу гаргаж өгөх шаардлага зарим байгууллагад бий болно.
10.Микро эдийн засгийн хүрээнд	10.1 Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Бизнесүүдийн бүтээмж, өгөөж нэмэгдэнэ
	10.2 Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		Бизнесүүдийн бүтээмж, өгөөж нэмэгдэнэ

	10.3 Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1 Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		

Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1 Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2 Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3 Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4 Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1 Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2 Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3 Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	2.4 Шинээр ажлын стандарт гаргаж ирэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5 Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлтийг бий болгох эсэх	Тийм		Зарим системд шинээр гаргах тайлан, мэдээллийн төрлийг нэмнэ.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1 Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2 Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүйчүүдэд, үндэстний цөөнхөд г.м		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3 Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1 Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2 Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм		Хандсан иргэдэд мэдээлэл, тайланг өгөх шаардлага үүснэ..
	4.3 Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм		Төрийн албан хаагч үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.
	4.4 Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	

	4.5 Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1 Хувь хүний/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2 Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эс эх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3 Хүмүүсийн амьдралын хэв маяг /хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ/-т нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1 Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм		Бизнесүүдийн бүтээмж нэмэгдэнэ
	6.2 Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3 Иргэдийн боловсрол /төрийн болон хувийн хэвшлийн сургуулиар/ олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4 Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	6.5 Их дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1 Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2 Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3 Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4 Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1 Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2 Хэл соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3 Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

Хүснэгт 5.

Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1 Зохицуулалтын үр дүнд агаар бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

2.Зам тээвэр, түлш эрчим хүч	2.1 Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2 Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3 Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4 Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамал хамгаалах	3.1 Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2 Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3 Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4 Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1 Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2 Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3 Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.1 Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

5.Хөрсний бохирдол	5.2 Хөрсийг эвдлэх, талбайн нэмэгдүүлэх эсэх ашиглагдсан хэмжээг		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1 Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2 Газрын зохицуулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3 Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй баялаг	7.1 Самар, жимс зэрэг нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг түүний нөхөн сэргээлтийн хугацаанаас өмнө ашиглах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2 Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Иймээс аргачлалын 7-д зааснаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонгосон.

Хувилбаруудын эерэг болон сөрөг тал, зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцаа, хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, хууль тогтоомжтой нийцэж буй эсэх, гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж, хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой гэж дүгнэлээ.

ДОЛОО. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Төрд үүсэн буй мэдээллээ нээлттэй болгож буй шийдэл, харилцааг олон улсад OPEN DATA гэж нэрлэн өөрийн үйл ажиллагаа, хууль журамдаа тусгайлан зааж өгсөн олон орон байна.

АНГЛИ УЛС

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

1. Нэг систем дээр төвлөрүүлэх

Төрийн өгөгдлийг нэг цэгт төвлөрүүлэн олон нийтэд нээлттэй байршуулдаг Англи улс <https://data.gov.uk>, АНУ улс <https://data.gov> зэрэг улс байна.

Аль болох хялбар байлгах зорилгоор датаг салбар бүрээр төрөлжүүлэхийн зэрэгцээ, хайлтын систем, тухайн салбарт ашиглагддаг аппликэшн, газрын зураг, нэмэлт мэдээлэл авах зэрэг хэсгүүдийг шийдэж өгчээ.

Иргэд (G2C) болон бизнесийн байгууллагууд (G2B), бусад төрийн байгууллагууд (G2G) шаардлагатай датагаа эндээс авч ашиглах, дахин боловсруулах, цааш нь түгээх боломжтой.

Зургийг data.gov сайтаас ашиглав.

2. API нэвтрүүлэх

Датаг зөвхөн вэб сайт дээр нээлттэй тавиад зогсохгүй иргэн, аж ахуйн нэгжүүдэд ашиглуулах, хуваалцах зорилгоор API (Application Programming Interface)-үүдийг гаргаж өгдөг.

СОЛОНГОС УЛС

Бизнесийн байгууллагууд, хувь хүмүүс уг интерфэйсийг ашиглан шинэ үйлчилгээ нэвтрүүлэх боломжтой. Үүнийг үр дүнтэй хэрэгжүүлсэн улс бол Австрали улс юм. Энэ талаар дэлгэрүүлж харахыг хүсвэл Австрали улсын NSW мужийн системээс (<https://api.nsw.gov.au/>) харна уу. Эндээс жишээ болгон авч үзвэл ШТС-ын байршил болон шатахууны үнийн талаар мэдээлэл өгөх API-ийг ашиглан өөрт ойрхон хямд үнэтэй ШТС хайж олон аппликэшныг бүтээжээ. Үүнтэй төстэйгээр авто замын ачааллын талаар мэдээлэл өгөх, үл хөдлөх хөрөнгийн салбарын бизнес эрхлэгчдэд зориулан тусгай зөвшөөрлийн талаар мэдээлэл авах, шалгах, сунгах зэрэгт шаардлагатай мэдээллийг олгох зэрэг маш олон API -уудыг хөгжүүлж нийтэд санал болгожээ.

Мөн бизнесийн байгууллагууд өөрсдийн бүртгэлийн систем дээр татвар төлөгчийн дугаар, нэртэйгээ таарч байна уу, авто машины дугаар эзэмшигчтэйгээ таарч байна уу зэргийг шалгах хэрэгцээ гардаг. Эдгээр асуудлыг бас уг аргаар шийдсэн байдаг.

Манай улсын хувьд одоогоор ЗГ датаг нийтэд нээлттэй болгосон цогц систем хараахан байхгүй байна. Бид ЗГ-ын датаг нийтэд нээлттэй болгосноор ил тод байдал дээшилж бизнес эрхлэгчид шаардлагатай мэдээллээ саадгүй авах боломж бүрдэнэ. Иргэд төрийн үйл ажиллагаанд хяналт тавих боломж бүрдэж мөн иргэдийн оролцоо нэмэгдэнэ. Түүнчлэн ЗГ-ын агентлаг хоорондын дата солилцоо сайжирна.

Иргэдэд болон бизнес эрхлэгчдэд шаардлагатай датаг зөвхөн вэб сайт дээр нээлттэй болгохоос гадна дээр дурдсанчлан мэдээллийн технологийн боломжийг ашиглан харилцан мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх нь зүйтэй юм. Ингэснээр төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа нэмэгдэж төрийн үйлчилгээний хүртээмж сайжирна.

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

н засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, хууль тогтоомжтой нийцэж буй эсэх, гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж, хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх

НАЙМ. ЗӨВЛӨМЖ

Хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг зохих журмын дагуу хийж гүйцэтгэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд нэмэлт оруулах төслийг боловсруулахдаа мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, төрлийг нарийвчлан заахын тулд дараах холбогдох хуулиудын зүйл заалтыг судалж, нэмэлт оруулах шаардлагатай.

Үүнд:

- Хувь хүний нууцын тухай хууль
- Байгууллагын нууцын тухай хууль
- Төрийн болон албаны нууцын тухай хууль
- Статистикийн тухай хууль
- Төв банкны тухай хууль
- Гаалийн тухай хууль

Хоёр. Хууль батлагдсантай холбогдуулан дагалдан гарах Засгийн газрын тогтоол, холбогдох журмуудыг боловсруулах шаардлагатай байна. Тухайлбал:

- Нэмэлтээр өгөх боломжтой мэдээллийн жагсаалт, загвар
- Мэдээлэл тус бүрийн үнэлгээ

Гурав. Хуулийн хэрэгжилтийг хангахын тулд хуулийг олон нийтэд сурталчлан таниулах, хуулийн үйлчлэлд хамаарах хувь хүн, хуулийн этгээдүүдэд мэдлэг, мэдээллийг тухай бүр хүргэх, мөн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх төрийн байгууллагын ажилтан, албан хаагч нарт сургалт, семинарыг зохион байгуулах нь

зүйтэй.